

**8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

А хувилбар

Сурагчийн нэр:.....
Даалгавар бүр 1 оноо

Хугацаа 60 минут

1.Эхээ анхааралтай сайтар уншиж ойлгож дараах даалгаврыг гүйцэтгэх.

2. Тусдаа цаас гарган даалгаврыг гүйцэтгэх .

Хөрөнгө сахигч

Нүүдэлчин малчин монгол хүнд нохой шиг тустай, үнэнч нөхөр үгүй гэж хэлж болно.

Хоточ сайн нохой бол тэр айлын мал сүрэг, эд хогшил, гэр орныг төдийгүй хүнийг нь сахиж хамгаалж байдаг. Малчин айл бүхэн нохой тэжээдэг заншилтай учраас монголд нохойгүй айл байсангүй. Уяаг нь уртасгаж угаадасыг нь нэмэн тэжээсэн нохой гэдэг эзэндээ ээлтэй, чоно хийгээд хулгайд арангатай, айлын хөрөнгө хадгалагч амьд "цоож түлхүүр" гэлтэй.

Иймээс монголчууд эрт дээд үеэсээ нохойг тэжээн гэрийн тэжээмэл амьтан болгож гаршуулаад, амьдрал аж зуулгын хөрөнгөө, амь насаа ч хамгаалуулж байсан түүхтэй төдийгүй хоточ сайн нохойгоо өрхий ам бүлийн тоонд оруулж хүншүүлэн хайрладаг уламжлалтай байжээ. Ийнхүү хүн нохой хоёр эртний ерөөлөөр учирсан анд сайн нөхөд болно. Нохойг хүний төрөлд ойртсон амьтан гэдэг бөгөөд нохой үхвэл хүн, хүн үхвэл нохой болдог гэж хэлэлцдэг.

Малчин айлын ам бүлд багтдаг ач тустай нохойны өөрт нь оногдсон хөрөнгө гэвэл ганц идүүр нь. Нүүхдээ нохойныхоо идүүрийг эсгийд боон сүүлийн тэмээнд ачаалаад "Сүүлчийн тэмээний ачаа хүндээ" гэж хэлүүт хөсөг хөдөлдөг авай. Энэ хэлц нь ачааны буюу идүүрийн хүндийг биш, тэр айлын хамаг хөрөнгө, хүн малыг сахидаг нохойны ганц өмч болсон идүүрт хүндэтгэл илэрхийлсэн хүнлэг ёсны агуулгатай ажээ.

Д. Баттогтох

1.Эхийн гол санааг багтаасан өгүүлбэрийг олоорой. \ 2 оноо \

А. Хүн нохой хоёр эртний ерөөлөөр учирсан анд сайн нөхөд болно.

Б. Малчин айлын ам бүлд багтдаг ач тустай нохойны өөрт нь оногдсон хөрөнгө гэвэл ганц идүүр нь.

В. Нохойг хүний төрөлд ойртсон амьтан гэдэг бөгөөд нохой үхвэл хүн, хүн үхвэл нохой болдог гэж хэлэлцдэг.

Г. Нүүдэлчин малчин монгол хүнд нохой шиг тустай, үнэнч нөхөр үгүй гэж хэлж болно.

2.Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийн далд утгыг олоорой.

\ 2 оноо \

Уяаг нь уртасгаж угаадасыг нь нэмэн тэжээсэн нохой гэдэг эзэндээ ээлтэй, чоно хийгээд хулгайд арангатай, айлын хөрөнгө хадгалагч **амьд "цоож түлхүүр"** гэлтэй.

А. Нохойг цоож түлхүүртэй адил найдвартай гэсэн санааг илэрхийлсэн.

Б. Нохойг цоож түлхүүртэй байдаг гэсэн санааг илэрхийлсэн.

В. Нохойг хүний төрөлд ойртсон амьтан гэж илэрхийлсэн.

Г. Нохой эзэндээ ээлтэй амьтан гэсэн санааг илэрхийлсэн.

3. “Сүүлчийн тэмээний ачаа хүнд” гэсэн хэлцийг ямар учраас ингэж хэлдэг болох шалтгааныг бичнэ үү? 2 оноо

.....

 илэрхийлсэн.

4. “Солонгос хүүхдийн арьсан гутал зарна” гэсэн өгүүлбэрийн найруулгын алдааг олж, засан бичээрэй. \ 2 оноо \

.....

5. Дараах гадаад үгийн зөв бичигт тохирох жишээ бичээрэй. 2 оноо

- “к” үсгээр төгссөн эр үгэнд “ий” эгшиг залгана.
- Нэг үгэнд хэд хэдэн өөр эр эгшиг байвал аль өргөлттэй эгшигт нь зохицуулан залгавар залгана.
- Орос хэлний “у” үсгийг Монгол хэлний “ү” эгшигтэй адилтган эм эгшигт тооцож залгавар залгана.
- Гадаад үгэнд ямар нэг эр эгшиг байхгүй бол эм үгийн “ий” залгана.

6. Уран зохиол : Туульсын бичвэрээс эшлэл авч, Хан Харанхуй баатрыг тодорхойлох . 5 оноо

Зохиолын баатрууд	Эшлэл
Эрхэм сайн нэр ус	
Өргөн сайхан нутаг ус	
Өндөр дээд угсаа гарал	
Албат иргэд , мал хөрөнгө	
Хүлэг сайн морь	

7. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.

\ 5 оноо \

1. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 2. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 3. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 4. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 5. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 6. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 7. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 8. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 9. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.
 10. Үндэсний бичгийг уншаад, кирилд хөрвүүлээрэй.

.....

**8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Б хувилбар

Сурагчийн нэр:.....
Даалгавар бүр 1 оноо

Хугацаа 60 минут

1.Эхээ анхааралтай сайтар уншиж ойлгож дараах даалгаврыг гүйцэтгэх.

2. Тусдаа цаас гарган даалгаврыг гүйцэтгэх .

БААВГАЙ БУУСАН НАМАР

Нэг намар Хэнтийн нурууны баавгайнууд бараг цөмөөрөө буугаад ирж билээ. Тэр бол 1988 он байсан юм байна. Баавгай уг нь ян сарьдгуудын гүнд балар тайгад шивээлэн амьдардаг амьтан. Ил гарч хүн малд харагдах нь бараг үгүй. Аймшигт махчин араатан. Тийм атлаа дан махаар хоолшдоггүй, заавал самар, жимс ургамлын гаралтай хоол тэжээл хольж иддэг онцлогтой. Ичээлэхийнхээ өмнө самраар өөрийгөө бордож хаанаас нь ч харсан халбаганасан амьтан болох ёстой. Гэтэл тэр жил хөвчид самар гарсангүй. Намар болж ургамал гандсанаар баавгай таргалах нь байтугай турж эхэлжээ. Өлссөн баавгай элбэгээр нь улаан шоргоолжны үүр ухаж эхэлдэг байна. Шоргоолжинд альдегид хэмээх спирт бий. Тэрэнд нь согтсоор байгаад архины цагаан солио тусаж хаашаа ч хамаагүй тэнэж юуг ч хамаагүй хийдэг. Ийм баавгайг ард түмэн хорхойтсон баавгай гэж нэрлэдэг билээ.

Тэд айлын эзгүй гэр хадланчдын майхан ухаж, идэж уучихмаар юм байвал цөлмөж дуусгана. Адуу мал руу ч халддаг. Тэр жилийн баавгайн хорхойтолтыг шинжлэх ухааны академи нарийн судалгаа гаргуулж хохирлыг тооцжээ. Батсүмбэрийн зөгий үржүүлгийн газар, мөн Хужирт, Моност тохойн 40 бүл зөгийг сүйтгэж хамаг балыг нь идэж дуусгасан байна. Естийн рашаан их хохиролтойд тооцогдоно. Бурхны том байшинг нь нурааж бурхан тахил идээ будааг нь ёстой будаа болгож дууссан билээ. Сүүлдээ рашаанчдын очдог замыг нь эзлэн авч, тав хоног гэр майхнаас нь гаргахгүй сахисан байдаг. Тэднийг анчид ирж аварчээ.

Хорхойтох үзэгдэл наймдугаар сарын дундаас арван нэгдүгээр сарын эхэн буюу бараг ичээнд орж дуусах үе хүртэл үргэлжилжээ. Олон зуун баавгай бууж ирсэн гэж үздэг бөгөөд харин ууландаа эргэж харьсан нь цөөхөн гэнэ. Хүмүүс ихэнхийг нь галзуурч, согтуурснаар нь далимдуулж агнаж устгаж арьс, өөх, доньт саврыг нь авч хоцорсон юм

Баавгай хэнэггүй, зоригтой, бас нэрэлхүү. Нэрэлхүү нь бүүр хэт. Илт давамгай зэвсэглэсэн анчидтай тааралдлаа ч зугтана гэж байхгүй. "Нэрэнд муухай юм даа" гэх шиг өөдөөс нь алхаж байгаад шүршүүлчихдэг.

1.Эхэд дэвшүүлсэн асуудлыг олж тайлбарлана уу. /2 оноо/

- А. Баавгай хэнэггүй, зоригтой амьтан юм.
- Б. Хүний буруутай үйл ажиллагаанаас болж байгаль, ан амьтанд гарч буй сөрөг үр дагаврын тухай
- В. Ойгоос бууж ирсэн баавгайн тухай
- Г. Хорхойтсон баавгайнаас болгоомжлох тухай

2.Баавгай “нэрэлхүү” амьтан гэдгийг баталсан өгүүлбэрийг олоорой.\2 оноо\

А. Баавгай уг нь ян сарьдгуудын гүнд балар тайгад шивээлэн амьдардаг амьтан.

